



МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮНД НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ

Товч удирдамж: Нэр дэвших тухай хүсэлт гаргахдаа энэхүү загварт асуусан асуулт, шаардсан мэдээлэл бүрийн доор /ард/ хариултаа үнэн зөв бичнэ. Компьютерын програм ашиглаж бичсэн хүсэлтийг цаасаар хэвлэж гарын үсэг зурах бөгөөд уг эх хувь, түүний хавсралт мөн Word-ын файлыг цахим шуудангаар тус тус Байнгын хороонд явуулна.

Хуульд заасан шаардлага: Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн нь банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн чиглэлээр мэргэшсэн, эдгээр салбарын ажлын дадлага туршлагатай, ёс зүйн хувьд төлөвшсөн, дараахь шаардлагыг хангасан хүн байна:

1/ Монгол Улсын 30-аас дээш насны иргэн, ял шийтгэлгүй;

2/ банк, санхүү, эдийн засаг, хууль зүйн мэргэжлээр магистрын болон түүнээс дээш зэрэг, цолтой.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:

5.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр банк, санхүү, эдийн засгийн салбарын асуудал хариуцсан төрийн байгууллагад өмнө нь ажиллаж байсан хүнийг томилж болно.

6.Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнээр Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, төрийн улс төрийн бусад албан тушаалтан, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, төрийн захиргааны албан тушаалтан, Монголбанкны удирдах албан тушаалтныг томилж үл болно.

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, НИЙТЛЭГ ШААРДЛАГА

1.1	Эцэг/эхийн нэр: Данзанбалжир Ургийн овог: Бэсүд Нэр: Энхжаргал Хүйс: Эмэгтэй Төрсөн он: 1964 Төрсөн газар: Улаанбаатар Иргэний харьяалал: Монгол Одоо оршин суугаа аймаг /нийслэл, сум/ дүүрэг: СБД, 1-р хороо, 12/3 байр, 11 тоот /мэдээлэл гаргагчийн зөвшөөрлөөр/
-----	---

1.2	Нэр дэвших тухай хүсэлт гаргаж буй албан тушаал МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН
1.3	Иргэний харьяалал Монгол Улсын иргэн

1.4	Боловсрол Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн он дарааллаар жагсааж, холбогдох нотлох баримтыг хавсаргана. <i>/сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ/</i> .				
	д/д	Суралцсан улс, сургуулийн нэр	Элссэн, төгссөн он, сар	Эзэмшсэн мэргэжил	Гэрчилгээ, дипломын дугаар
	1	АНУ, Вандербилдын Их сургууль	1997-9/1999-6	Хөгжлийн Эдийн засаг-магистр	Гэрчилгээ
	2	ОХУ, Эрхүүгийн Улс Ардын Аж Ахуйн Дээд сургууль	1982-9/1986-6	Санхүү банкны эдийн засаг- Мөнгө Зээл	KB533002 Баклавр
1.5	Боловсролын болон шинжлэх ухааны докторын зэрэг Лондонгийн их сургуулийн докторант				
1.6	Эрүүл мэнд Сэтгэцийн өвчин, эмгэггүйг тодорхойлсон нотлох баримтыг хавсаргав.				
1.7	Эрхэлсэн ажил Их, дээд сургууль төгссөнөөс хойш эрхэлсэн ажлыг тодорхойлон бичнэ. Эдийн засаг, банк, санхүү, эрх зүйн аль нэг чиглэлээр эзэмшсэн мэргэжлээрээ ажилласан туршлагатай, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадвартай болохыг нотлох баримтыг хавсаргана. Ажилласан байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дарааллаар жагсаах бөгөөд ажил олгогч <i>/эсхүл, удирдах албан тушаалтан/-ийн нэр, хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ.</i> <i>Данзанбалжирын Энхжаргал би банк санхүүгийн салбарт 38 жил ажиллаж байгаагаас Монгол Улсын Төв банкинд 30 гаруй жил тогтвортой ажиллахдаа нягтлан бодогчоос ажлын гараагаа эхэлж, эдийн засагч, мөнгөний бодлогын болон хяналт шалгалтын газрын захирал, Лондон дахь төлөөлөгч, Дэд Ерөнхийлөгчөөр ажилласан. ИБУИНВУ дахь Монголын ЭСЯ, Монгол Улс-Европын Холбооны хамтарсан төсөл, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкинд зөвлөхийн үүрэг гүйцэтгэж байсан. Банк, санхүү, хөгжлийн эдийн засгийн чиглэлээр мэргэжсэн. ОХУ-ын Байгалын Улсын их сургуулийг баклавр, АНУ-ын Вандербилт их сургуулийг шинжлэх ухааны магистр, Монголын худалдаа бизнесийн их сургуулийг бизнесийн удирдлагын магистрээр төгсөж, Английн Оксфордын их сургуульд эрдэс баялгийн засаглалын мэргэжил дээшлүүлсэн. Үнэт цаасны хорооны анхны гишүүн, Англид Fidelity Asian Values ХК, Оюу Толгой ХХК, Эрдэнэс Монгол ХХК, МТЗ ТӨХК, Төрийн банк ХК, Монос ХК зэрэг нэр хүнд бүхий томоохон компаниудын ТУЗ-ын гишүүн, Хараат бус гишүүн, Аудитын Хороо, Нэр дэвшүүлэх хорооны дарга, Хөдөлмөр нийгэм хамгааллын сайд, Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн даргын зөвлөх, Олон улсын Хөрөнгө Оруулалтын Банкны Захирлуудын Зөвлөлийн Монголын захирал, Мянганы Сорилтын санд Интерим гүйцэтгэх захирлаар ажилласан. НҮБ-д зөвлөх эрхтэй олон улсын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын Ази Номхон далай хариуцсан Дэд Ерөнхийлөгчөөр 10 жил сонгогдон ажилласан. Европ дахь Монгол эмэгтэйчүүдийн хөгжлийн холбоо, Эрдэс баялгийн эмэгтэйчүүдийн холбооны үүсгэн байгуулагч, Санхүү банкны эмэгтэйчүүд, Даян дэлхийн Монгол эмэгтэйчүүд хамтдаа зэрэг ТББ-уудын Ерөнхийлөгч, Тэргүүнээр ажилладаг. Монгол улсад 2 шатлалт банкны тогтолцоог бий болгон хөгжүүлэх, банкны салбарыг хямралаас гаргах бүтцийн өөрчлөлтийг санаачлан 1996 онд банкны эрх зүйн шинэчлэлтийг эхлүүлж хэрэгжүүлсэн. Монголбанк, Төрийн банкны тодорхойлолтыг хавсаргав. Үргэлжлэлийг 1.7 хавсралтаас үзнэ үү</i>				

<p>1.8</p>	<p>Ашиг сонирхлын зөрчил</p> <p>Банк бус санхүүгийн байгууллага, банкны хувьцаа эзэмшдэггүй.</p> <p>Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшдэг эсэхийг бичих.</p> <p><i>Тийм</i></p> <p><i>Базальт ХК-ийн 7981 хувьцаа, 2018</i></p> <p><i>Аарч консалтинг ХХК 20 хувь, үйл ажиллагаа явуулдаггүй, 2016</i></p> <p><i>Хүүбат ХХК 50 хувь, үйл ажиллагаа явуулдаггүй, 2013 он</i></p> <p><i>Иргэн бүрт хуваарилсан ЭТТ ХК-ийн 1072ш хувьцаа, 2012</i></p> <p>Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг эсэхийг бичих.</p> <p>Үгүй</p>
<p>1.9</p>	<p>Улс төрийн болон намын удирдах, гүйцэтгэх албан тушаал</p> <p>Сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан эсэх</p> <p>Үгүй</p>
<p>1.10</p>	<p>Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар</p> <p>Сүүлийн таван жил ямар мэргэжлийн холбоо, байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байсан, гишүүнчлэлийн талаар бичих.</p> <p>Үгүй</p>
<p>1.11</p>	<p>Мэргэжлийн ёс зүйн талаар</p> <p>Мэргэжлийн ёс зүйн зөрчил гаргаж байсан эсэх.</p> <p>Үгүй</p>

1.12 Хэрэв доор дурдсан мэдээлэл нэр дэвшигчид байгаа бол

-Өөрийн боловсруулсан, хянасан судалгааны ажил, ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.

-Өөрийн харьяалагддаг байгууллагын нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэлэлцүүлсэн лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, ярианы товч утга, огноо, газар, танилцах арга замыг бичнэ. Тухайн илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч утгыг бичнэ.

-Сүүлийн таван жилийн хугацаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлага, нийтлэлийг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлага, нийтлэлүүдийн огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэг, нийтлэлийг хуулбарлан өгнө.

/Жич: Дээр дурдсан материал тус бүрээс нэгийг хавсаргах бөгөөд боломжтой бол цахимаар үзэх линкийг тусгана/

Дэлхийн дулааралд дасан зохицох чадавхийг бэхжүүлэх шинэлэг, ухаалаг хөрөнгө оруулалт, мэдлэг дамжуулах стратегийн түншлэл: Мянганы сорилтын II компакт, Мөнгө, санхүү, баялаг сэтгүүл, 2022.

Д.Энхжаргал: Эдийн засагт “хар хун”-гийн үзэгдэл тохиолдоод байна, 2020.05.11 <https://www.facebook.com/eguur.news/posts/530301577637285/>

Д.ЭНХЖАРГАЛ: Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл шуурхай ажиллаж, иргэдээ стрессээс гаргах хэрэгтэй, ярилцлага 2020.03.09 <https://www.unuudur.mn/a/123164>

Монгол Улсын Засгийн газрын Төрийн санхүүгийн удирдлагын шинэчлэлийн дунд хугацааны стратеги (2018-2020), Арнольд Хойтинктэй хамтран боловсруулж, Монгол Улсын Сангийн сайдын тушаалаар 2018 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр баталсан.

Санхүүгийн салбарын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө, хөтөлбөрүүд боловсруулсан. Монгол улсын санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал болж Засгийн газрын 2001 оны 125 дугаар тогтоолоор батлагдсан. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=201140>

Монгол Улсын эрдэс баялгийн өсөлтийг санхүүжүүлэх нь, 1 Inner Asia 6 (2014) 275–300; Ч. Хашчулуунтай хамтарсан хэвлэл, 2014, Koninklijke Brill NV, Leiden, Кэмбриджийн Их сургууль дээр зохион байгуулсан Монголын хөрөнгө оруулалтын чуулга хурал дээр хэлэлцүүлсэн илтгэл.

Банкны хөгжилд эмэгтэйчүүд -100 жилийн ой (1924-2024), Монголын Банк Санхүүгийн Эмэгтэйчүүд ТББ, 2024.

Зууны 100 эмэгтэй (1921-2021), I, II боть, Даян Дэлхийн Монгол Эмэгтэйчүүд Хамтдаа ТББ, 2020, 2021,

Банкны, Төв банкны тухай хууль, Иргэний хууль, Векселийн тухай хууль, Мөнгөн хадгаламжийн баталгааны тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, мөн түүнчлэн банк санхүүгийн холбогдолтой 40 гаруй заавар журмуудыг санаачлан боловсруулж, нөөц мөнгөний удирдлага, заавал байлгах нөөц, төв банкны үнэт цаас, вексель, банкуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт тавихтай холбогдсон зээлийн ангилал тогтоох, зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тогтоох зэрэг зах зээлийн санхүү банкны зохицуулалтын үндэс суурийг тавихад манлайлж, зээлийн мэдээллийн санг санаачлан зохион байгуулж, банк санхүүгийн бүтээгдэхүүний үндэсний стандартыг бий болгож, инфляцийг бууруулах, банк санхүүгийн салбарыг зах зээлийн эдийн засагт нийцүүлэн өөрчлөн шинэчлэх үйлсэд идэвхи зүтгэл гарган ажилласан. Иргэний хуулийн шинэчилсэн болон өмнөх найруулгад зээлийн харилцаанд оролцогч талуудын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбогдсон заалтуудыг санаачлан боловсруулсан нь банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад суурь ач холбогдолтойд тооцогдож үнэлэгдсэн. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний төлбөр тооцооны зөвлөлийг байгуулах санаачлага гарган, иргэдийн хадгаламжийг үнэгүйдлээс хамгаалах, гадаад валютын улсын нөөцийн удирдлагын арга барилд эрсдэлд суурилсан зарчмын шинэчлэлт хийн олон улсын түвшинд хүргэж, нөөцийг нэмэгдүүлж, эрсдлээс хамгаалах тогтолцоог нэвтрүүлснээр, дэлхийн санхүүгийн хямралыг богино хугацаанд даван туулах, валютын нөөцийг хомсдолоос гаргах ажлыг удирдан ажилласан.

ХОЁР. ХИЙХ АЖИЛ, НЭР ДЭВШСЭН ҮНДЭСЛЭЛЭЭ БИЧСЭН ТАЙЛБАР

- 2.1 Тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, уг албан тушаалд нэр дэвшсэн үндэслэлээ тайлбарлаж тодорхой, ойлгомжтой бичнэ.
/500-1000 үгэнд багтаана/.

Монголбанкны нябо бүртгэлийн хяналтаас ажлаа эхлүүлж, эдийн засагч, захирал зэргээр мөнгөний бодлого, хяналт шалгалт, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг удирдан, Дэд Ерөнхийлөгч байхдаа төлбөр тооцоо, мэдээллийн технологи, бүртгэл, валют эдийн засгийн газруудыг хариуцан тасралтгүй ажилласан 30 гаруй жилийн туршлага, банк санхүү эдийн засгийн мэдлэг мэргэшилдээ үндэслэн Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажлыг мэргэжлийн өндөр түвшинд ёс зүйтэй, хариуцлагатай, авлигаас ангид, хүний эрхийг дээдлэн ажиллах хүсэл зориг, тэмүүлэлтэй байгаа бөгөөд хэрвээ тухайн албан тушаалд томилогдвол Хяналтын Зөвлөлийн ажлыг дэлхийн сайн жишигт нийцүүлэн хүргэх зорилт тавин дараахь ажлуудыг санаачлан зөвлөлийн хамт олонтой хамтран хэлэлцэж, хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

Монголбанкны хяналт удирдлагын одоогийн засаглалын бүтэц зохион байгуулалт нь орчин үеийн Төв банкны дэвшилтэт зохистой түвшингээс хоцрогдсон. Иймд сайжруулж боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай. Энэ талаар Монголбанкны Хяналтын зөвлөлийн хурлын тайлангуудад удаа дараа

дурьдагдсан байна. Монголбанкны жилин тайлан, УИХ-ийн ТГ-ын Хяналт шалгалт, үнэлгээний газрын тайлан зэрэг нийтэд ил тод болсон мэдээллээс үзэхэд 2018-2022 онд хөндлөнгийн аудитороос санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт авсан хэдий ч засч залруулагдаагүй олон жил болсон байна. Монголбанкны алдагдлын хэмжээ өсч ₮7,4 их наяд болж, дүрмийн сангаас мянга илүү дахин нэмэгдсэн нь бодьтой үр дүнтэй арга хэмжээ авч бүрэн шийдвэрлээгүй, өнөөг хүрсэн гэх дүгнэлтэд хүргэж байна. Мөн түүнчлэн Олон улсын валютын сангийн өгсөн зөвлөмжүүд хангалттай хэрэгжсэн гэх дүгнэлт байхгүй байна. Иймд Төв банкныг санхүү эдийн засгийн хувьд хүчирхэг болгохуйц бүтцийн өөрчлөлтийг Төв банкны хуульд өөрчлөлт оруулах замаар эрх зүйн шинэчлэлт нэн яаралтай хийх хэрэгтэй. Ингэснээр Төв банканд олон нийтийн итгэх итгэл сэргэж, зохистой зөв засаглал бүхий хяналт эрсдэлийн удирдлага бий болж, хуулиар заасан үндсэн зорилт үүрэгт ажлуудыг бие даасан хараат бус байдлаар хэрэгжүүлэн ажиллах таатай нөхцөл бүрдэж, улмаар Монгол улсын банк санхүүгийн салбарт эергээр нөлөөлж, тогтвортой хүртээмжтэй хөгжилд түлхэц болно. Үүнд;

1. Зохистой хяналт удирдлагын тэнцвэртэй байдлыг бий болгохуйцаар Төв банкны хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Төв банкны Удирдах Зөвлөлийг бий болгох, эрх үүргийг хуульчлах, Хяналтын Зөвлөлийн журмыг шинэчлэх,
2. Аудит эрсдэлийн хороог байгуулах, дотоод аудитын удирдлагыг Ерөнхийлөгчөөс шууд хамааралтай байгааг болиулж, Аудит Эрсдэлийн хороогоор сонгон шалгаруулах, гэрээ байгуулах замаар Монголбанкны шууд удирдлагаас хараат байдлыг арилгаж, бие даасан байдлыг хангах
3. Монголбанкны эрсдэлийн нэгдсэн үнэлгээ, шалгуур, тодорхойлолтыг гаргах, их хэмжээтэй өндөр дүнтэй гэрээ хэлцлийг Аудит эрсдэлийн хороогоор дамжуулан Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж баталдаг болох,
4. Төв банкны санхүү эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлж, хараат бус байдлыг сайжруулах дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах, стратегид Сангийн Яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас санал авч, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, санал зөвлөмж авах, Засгийн газартай зөвшилцөх, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах, дэмжлэг авах
5. 7 их наяд төгрөгийн хуримтлагдсан алдагдлыг үе шаттай бууруулах зорилтот түвшин, тооцооллыг гаргах,
6. Дүрмийн санг нэн яаралтай 2 дахин нэмэгдүүлж, дор хаяхад арилжааны банкны түвшинд хүргэх зорилтот түвшинг тогтоох
7. Банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, дахин хөрөнгөжүүлэх,
8. Актив хөрөнгийн эргэлтийг сайжруулах, дахин үнэлэх,
9. Хуримтлагдсан чанаргүй актив, зээл, авлагын өр төлбөрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх,
10. Тэнцлийн гадуурх дансдын тооцоог, өр төлбөрийн хэмжээг хянаж шалгах
11. Хэмнэлтийн горимыг бүх шатанд мөрдүүлэх,
12. Санхүүгийн сахилга батыг хатуу чанга баримтлах,
13. Төв банкны үнэт цаасыг аажмаар багасгаж, Засгийн газрын богино хугацаат үнэт цаасыг эргэлтэнд оруулж, мөнгөний бодлогын хэрэгсэл болгон мөнгөний зах зээлд нийцүүлэн ашиглаж эхлэх,
14. Төв банкны үнэт цаас, алтны арилжаа, валютын дуудлага худалдаа, аукционы үр өгөөжийг дээшлүүлэх,

15. Төв банкны дижитал үйл ажиллагааг идэвхжүүлэх, илүү цахим, инновацлаг, ухаалаг болгох замаар зардал хэмнэх, бүтээлч болгох, цахим төгрөг гаргах эрх зүйн орчинг хөгжүүлэх,
16. Бэлэн мөнгийг тоолох, хэвлэх, тээвэрлэх, гүйлгээ, эмиссийн үйл ажиллагаа, эргэлтийг оновчтой зохион байгуулах,
17. Гүйлгээнээс хасагдах мөнгөн тэмдэгтийн тоо хэмжээг эрс бууруулах зорилт тавьж, бэлэн мөнгөний зохистой хэрэглээг олон нийтэд таниулах зардлыг бууруулах,
18. Монголбанкны зарим үйл ажиллагааг тухайлбал олон нийтийн санхүүгийн боловсрол олгох, сэтгүүл гаргах, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, Монголбанкны үйл ажиллагааг олон нийтэд таниулахтай холбоотой хэвлэл мэдээлэл (төлбөр тооцооны зохицуулалтаас бусад) зэрэг аж ахуйн шинжтэй үйл ажиллагааг аж ахуйн тооцоонд шилжүүлэх, хувийн хэвшил, ТББ-ын түншлэлийн хүрээнд зохион байгуулж, үргүй зардлыг арилгах,
19. Бүсчилсэн хөгжилтэй холбогдуулан салбар нэгжүүдийн үйл ажиллагааг илүү цомхон оновчтой үр өгөөжтэй, харилцан уялдаатай зохистой болгох,
20. Эрдэнэсийн сан, музейн үйл ажиллагааны хадгалалт, хамгаалалт, баяжуулалт, орлого зарлагын байдал, хөндлөнгийн аудитороос өгсөн үнэлэлт дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар шуурхай арга хэмжээг авах
21. Цалин урамшууллын хороог байгуулах, цалин урамшууллын бодлогыг ил тод болгох

Энэхүү саналыг гаргахдаа зөвхөн олон нийтэд ил тод тавигдсан тайлан мэдээлэл дээр үндэслэн гаргав. Нарийн тодорхой тоон болон хяналтын мэдээллүүд дээр үндэслэн илүү нарийвчилсан арга хэмжээнүүдийг төлөвлөх тооцох боломжтой.

Хүсэлт гаргагч:

Эцэг/эхийн нэр: Данзанбалжир

Өөрийн нэр: Энхжаргал

Гарын үсэг:



Он, сар, өдөр: 2024 оны 12 дугаар сарын 18